



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ТҮШИГ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
АРДЧИЛСАН НАМД

2024.08.05 № ГНАГ-2024/13-ЦТА-НА-32  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд  
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-т заасан төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь 2024 оны аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгосон.

018020574

## Дүгнэлт

Ардчилсан намын Түшиг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Түшиг сумын Ардчилсан намын мөрийн хөтөлбөр ( .....<sup>7</sup>..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Түшиг сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТҮШИГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН 2024 ОНЫ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ АРДЧИЛСАН  
НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



**ӨРХИЙН ӨСӨЛТ НУТГИЙН ХӨГЖИЛ**

Монгол Улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуульт ардчиллаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, нутгийн удирдлага, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд:

ТҮШИГ СУМЫН АРДЧИЛСАН НАМ 2024-2028 оны сумын ИТХ-ын сонгуульд **“НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ХУРДАСГАХ-ИРГЭНДЭЭ ЭЭЛТЭЙ ЗАСАГЛАЛ”** мөрийн хөтөлбөрөө та бүхэндээ танилцуулж байна.

**НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ, ЭРХ ЧӨЛӨӨ**

**1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол**

1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох **“ЗӨВ МОНГОЛ ХҮҮХЭД”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.1.2 Гадаадын их дээд сургуульд жил бүр 1-ээс доошгүй шилдэг сурагчдыг оюутны тэтгэлгээр суралцах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана.

1.1.3 Багш, суралцагчдын хөгжлийг дэмжих сургалтын цахим лаборатори, видео хичээл, е-сурах бичиг, онлайн сургалт, виртуал орчин бүхий сургалтын нээлттэй тогтолцоо бий болгох бодлогыг хэрэгжүүлнэ.


1.1.4 Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ хүүхэд, иргэдийг дохионы хэлний сургалтад хамруулах үйл ажиллагааг дэмжиж, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн бодлого баримтална.

1.1.5 Сумын ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын багш, эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн ажилтан нарын мэргэжил мэдлэг, ур чадварыг хөгжүүлэхэд онцгой анхаарч, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.1.6 Сумын хүүхэд залуучуудыг гадаад хэлний боловсрол олгох сургалтад шат дараатай хамруулах бодлогыг дэмжиж, хамтарч ажиллана.

1.1.7 Жил бүр төгсөх ангийн хүүхдүүдийн мэргэжил сонголтод онцгой анхаарч **“НУТГИЙН ОЮУТАН ХӨТӨЛБӨР”**-г хэрэгжүүлж, нутгийн зөвлөл, орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.1.8 Боловсрол, эрүүл мэнд, төрийн захиргааны салбарт залуу боловсон хүчнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах бодлого баримтална.



## **1.2 Эрүүл мэндийн үйлчилгээ**

1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх **“ЭРҮҮЛ ТҮШИГЧҮҮД”** хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.2 0-17 насны хүүхдийн үзлэг оношилгоог нарийн мэргэжлийн эмч нараар хийлгэж, **“ЭРҮҮЛ ХҮҮХЭД”** сумын дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

1.2.3 Уламжлалт анагаах ухааны өв санд суурилж, уламжлалт эмчилгээ, үйлчилгээний брэнд бүтээгдэхүүнийг хөгжүүлэх, төрийн бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2.4 Эмийн найрлагад ордог амьтан, ургамал, эрдсийн нөөцийг хамгаалж, тарималжуулж, үржүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжиж ажиллана.

1.2.5 Хуурамч, чанаргүй хүнсний бүтээгдэхүүний хяналтыг сайжруулна.

1.2.6 Хуванцар савны хэрэглээг бууруулах, иргэдийн эрүүл мэндэд нийцсэн **“ГАН САВ”** дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.


## **1.3 Хүн ам зүй, нийгмийн хамгааллын хүрээнд**

1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, эцэг, эхтэйгээ хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг хэрэгжүүлж, дэмжиж ажиллана.

1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесийг хөгжүүлэх, амьдрах орчноо хамтдаа сайжруулах, мэдлэг, ур чадварын сургалтад хамрагдах талаар дэмжиж, хамтран ажиллана.

1.3.3 Хүүхдийн хүчирхийллийн эсрэг тэмцэж, дарамт, мөлжлөгийн бүх хэлбэрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.3.4 Гэр бүлийн бат бэх байдлыг дэмжиж гэр бүл, нөхөн үржихүйн боловсролыг дээшлүүлж, өрх толгойлсон эцэг, эх, хүүхдийг эрсдэлээс хамгаалах бодлогыг хэрэгжүүлнэ.



## 1.4 Нийгмийн хамгаалал

1.4.1 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн бодлого боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтарч ажиллана.

1.4.2 Хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, оюутан, ажилгүй иргэдийн нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж, иргэдэд ирээдүйд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах чиглэлээр нийгмийн даатгалын байгууллагатай хамтран ажиллана.

1.4.3 Ахмад настанд зориулсан сувиллыг байгуулах асуудлыг төр, хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.

## 1.5 Соёл, урлаг, спорт

1.5.1 Сумын соёлын биет ба биет бус өвийг хадгалан хамгаалах, сэргээн засварлах, түүнийг хамгаалан цуглуулагч, тээн уламжлагч нарыг сурталчлан, дэмжиж ажиллана.

1.5.2 Археологийн болон түүх соёлын дурсгалт газрын бүртгэл, хамгаалалтыг сайжруулахад анхаарч ажиллана.

1.5.3 Түүх, соёл, танин мэдэхүйн агуулга бүхий контентыг хөгжүүлж, үзэгчдэд хүртээл болгох ажлыг зохион байгуулна.

1.5.4 Эрүүл, идэвхтэй аж төрөх талаар сургалт, сурталчилгааг сайжруулж, сумын хэмжээнд дугуйн зам, явган хүний зам барина.

## ХОЁР. ХӨГЖИХ БОДЛОГО

### 2.1 Өсөлтийн бодлого

2.1.1 Сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг төрөлжүүлэн, хөгжүүлнэ.

2.1.2 Өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд анхаарч, зах зээлд нийлүүлэх нөхцөл бололцоог хангана.

2.1.3 Байгалийн дагалдах баялгийг түшиглэн, иргэдийн аж байдлыг сайжруулах, эдийн засгийн хөгжлийг дэмжих олон тулгуурт бодлогыг баримтална.

2.1.4 Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын санал санаачилгыг дэмжин, **“Түшиг нутгаа хөгжүүлье”** төрийн бус байгууллага байгуулах, хөрөнгө оруулалтын хамтын сан бүрдүүлэх асуудлыг бодлогоор дэмжинэ.

## 2.2 Төсөв, санхүү, татварын бодлого

2.2.1 Төсвийн зардлыг ач холбогдол, үр өгөөжөөр нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үр ашигтай хуваарилалтын бодлого хэрэгжүүлнэ.

2.2.2 Орон нутгийн үйлдвэрлэгчдийнхээ бүтээгдэхүүнийг худалдан авах хандлагыг бий болгож, мөнгөн гүйлгээг нутагтаа авч үлдэх бодлого баримтална.

2.2.3 Хуримтлалыг бий болгох сургалтыг зохион байгуулж, ард иргэдийн хадгаламжийг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

## 2.3 Үйлдвэрлэл

2.3.1 Хөдөө аж ахуй, уул уурхайн салбарыг түшиглэн жижиг, дунд үйлдвэр байгуулах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2 Мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүний сумын хэрэгцээг хангаж, бусад сумдад борлуулалт хийх бодлого баримтална.

2.3.3 Мал нядалгааны төв, дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй, хүнс хадгалах зоорь зэрэг жижиг дунд үйлдвэрүүдийг төр, хувийн хэвшлийн оролцоотой байгуулж, хүн амыг шинэ ургацын ногоо, мах, махан бүтээгдэхүүнээр хангана.

2.3.4 Малын ашиг шим, малаас гарч байгаа дайвар бүтээгдэхүүн, түүхий эдийг боловсруулах ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.

2.3.5 Орон нутагтаа үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, төрийн бүх байгууллагууд хэрэглэх санал санаачилгыг дэмжиж, бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

## 2.4 Дэд бүтэц, барилга

2.4.1 Сумын төвийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн оролцоотой хэрэгжүүлнэ.


2.4.2 Зам, барилга, харилцаа холбоог нэмэгдүүлэх, иргэд орон нутагт амьдрах нөхцөлийг сайжруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.

2.4.3 Хүүхэд, залуусын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, стандартад нийцсэн тоглоомын талбай байгуулах ажлыг иргэн, аж ахуйн нэгжтэй хамтарч зохион байгуулна.

2.4.4 Хүн амын эрүүл мэндийг хамгаалах, хөрсний бохирдлыг бууруулах, "ЭКО 00" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

## 2.5 Эрдэс баялгийн салбар

2.5.1 Хариуцлагатай уул уурхайн олон улсын стандарт, шалгуур үзүүлэлтүүдийг иргэн, аж ахуйн нэгж бүр үйл ажиллагаандаа хатуу мөрдөж, ашигласан болон ашиглаж байгаа талбайг хамгаалах, нөхөн сэргээлтийг заавал хийж байх ажлыг хэвшил болгоно.



## 2.6 Аялал жуулчлал

2.6.1 Орон нутгийн иргэдийн амьдралд сайнаар нөлөөлөх, жуулчдад чанартай үйлчилгээ үзүүлэх, аялал жуулчлалын салбарын дэд бүтцэд хийх гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжиж, хамтран ажиллана.

2.6.2 Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллана.

2.6.3 Суманд жуулчид хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, орон нутгийн малчин иргэдийн орлогыг нэмэгдүүлэх "ГЭР АМРАЛТ" хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.6.4 "Зэлтэрийн гацаа", "Тамгат хад" зэрэг түүхэн газруудыг тохижуулах, хамгаалалтад авах ажлыг холбогдох байгууллагуудад уламжлан, шийдвэрлүүлнэ.

## 2.7 Шинжлэх ухаан, технологи, мэдээлэл харилцаа

2.7.1 Айл өрхийн хаягжилтыг сайжруулан, шуудан хүргэлтийн системийг боловсронгуй болгож, хог хаягдлыг ангилж, зайлуулах бодлогыг хэрэгжүүлнэ.

2.7.2 Сумын төвийн гудамж талбайг камержуулах, гэмт хэргийг таслан зогсоох ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

## ГУРАВ. ОРОН НУТГИЙН БОДЛОГО

### 3.1 Бэлчээр ашиглалт

3.2.1 Малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр бог малын үржлийн нэгж байгуулж, малын чанар, үр ашгийг нэмэгдүүлэх бодлого баримтална.

3.2.2 Сумын бэлчээр ашиглалтын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, бэлчээр ашиглах, ашиглуулах талаар хувийн хэвшлийн байгууллагууд болон малчидтай хамтарч ажиллана.

3.2.3 Малчин, мал бүхий иргэдийн хамтын хоршоо, бүлэгтэй хамтран бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлнэ.

3.2.4 Малын тоонд бус чанарт анхаарч, бэлчээрийн даацыг тохируулан түүнийг хамгаалж, сайжруулсан малчин өрх, бүлэг, хэсгийг дэмжинэ.

### **3.2 Газар тариалан**

3.3.1 Услалтын системийн менежментийг боловсронгуй болгож, гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг хөгжүүлэх снал, санаачилгыг дэмжиж, хамтарч ажиллана.

3.3.2 Экспортод чиглэсэн өндөр ашиг шимтэй, эрчимжсэн мал аж ахуйг газар тариалантай хослуулан хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.3 Малын тэжээлийн үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмжөөр хангах санал санаачилгыг бодлогоор дэмжиж ажиллана.

3.3.4 Ургамал хамгааллын орчин үеийн арга технологийг иж бүрэн хэрэгжүүлж, тариалангийн талбайн хөрсийг элэгдэл, хортон шавжаас хамгаалах, үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.3.5 Жимс, жимсгэнийн дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, импортыг орлох, чанартай, эко бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар хувийн хэвшилтэй хамтарч ажиллана.

### **3.3 Мал аж ахуй**

3.3.1 Мал аж ахуйн салбарыг эдийн засгийн үр ашигтай, орчин үеийн шинэ технологи, инновацад суурилж, хөгжүүлэх, мэдлэг бүхий малчдыг малчин бизнесмен болгох замаар тогтвортой орлого олох бодлогыг хэрэгжүүлнэ.

3.3.2 Сумын мал аж ахуйг хөгжүүлэх урт хугацааны төлөвлөгөө гаргаж, эцэг малын үүлдрийг сайжруулна.

3.3.3 Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, малын үржил, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмж, хяналтыг сайжруулна.

3.3.4 Махыг зах зээлд нэвтрүүлэх хяналтын горимыг сайжруулж, малын вакцин, туулгад бүрэн хамруулан, эрүүлжүүлэх ухаалаг хяналтын системийг нэвтрүүлнэ.

## **ДӨРӨВ: ХАРИУЦЛАГАТАЙ ТҮШИГ**

4.1 Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжин, авлигаас ангид ажиллах чадвартай, албан тушаалаас үл хамаарч хуулийн өмнө тэгш хариуцлага хүлээдэг, мэргэжлийн, хүртээмжтэй, цахимжсан нийтийн албыг бэхжүүлж, шинэчлэл хийн орон нутагтаа бүтээлч, бүтээгч засаглалыг бий болгоно.

4.2 Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг хамгаална.

4.3 Орон нутгийн төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

4.4 Төр, төсвийн байгууллагын удирдах албан тушаалтан жил бүр иргэдэд нээлттэй, ил тод ажлын тайлангийн сонсгол хийдэг ажлыг тогтмолжуулна.

4.5 Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.

4.6 Захиргааны ерөнхий хууль, Шилэн дансны тухай хууль, Нийтийн сонсголын тухай хуулиудад туссан иргэний оролцоотой хяналтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлнэ.

### **ТАВ: ЭКО СИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ**

5.1 Ан амьтан, загас гөрөөс, зэрлэг гахай зэрэг амьтдын өсөж үржих боломжийг хангах бодлого баримтална.

5.2 Хог хаягдлыг цуглуулах тээвэрлэх, хадгалах дахин ашиглах, сэргээн ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг үйл ажиллагааг шат дараалан авч хэрэгжүүлнэ.

5.3 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, шинэ технологи нэвтрүүлэх хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.

5.4 Ой, рашаан, булаг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг орон нутгийн иргэн, аж ахуйн нэгжээр хийж гүйцэтгүүлэх бодлого баримтална.

### **ТҮШИГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО**